



**“ДУЛААНЫ ТАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ОНӨААТҮГ-ЫН  
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**“ДУЛААНЫ ТАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ОНӨААТҮГ-ЫН  
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2026.01.21

Улаанбаатар хот

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хугацаа	Хариуцах нэгж	Арга хэмжээний гүйцэтгэл	Гүйцэтгэл хувь
1	2	3	4	5	6	7	8
<b>НЭГ. ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД</b>							
<b>Зорилт 1. Байгууллагын дүрэмд нийцсэн эрх хэмжээний хүрээнд төсөл хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх</b>							
1.1	ТЭЗҮ шинэчлэх бэлтгэл ажлыг хангах, өмнөх ТЭЗҮ-г дүгнэж, шинэчлэлийн шаардлагыг тодорхойлох	Хамрах хүрээ, шинэчлэх шаардлага тодорхойлогдсон байх	Шинэ ТЭЗҮ-г боловсруулж дууссан байна.	I улирал	ТТА	Эрчим хүчний салбарын экспертүүдийн санал, шүүмжийг тусган ТЭЗҮ-г шинэчилж дуусгасан.	100%
1.2	Шинэчилсэн ТЭЗҮ-г боловсруулах, ЭХЯ-ны ШУТЗ-д танилцуулж, батлуулах	ШУТЗ-д танилцуулсан баримт бичигтэй байх	ТЭЗҮ албан ёсоор батлагдсан байна.	I улирал	ТТА	Шинэчилсэн ТЭЗҮ-г 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр ЭХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан. Төслийн техникийн ажлын даалгаврыг ЭХЯ-с санал авч боловсруулсан.	100%
1.3	Төслийн урьдчилсан үнэлгээ болон бүрэн шинжилгээг хийхэд шаардлагатай мэдээллээр хангаж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон тооцоо, судалгааг хийхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх	Журмын хэрэгжилтийг хангасан байх	Урьдчилсан үнэлгээ болон бүрэн шинжилгээ боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлсэн байна.	I улирал	ТТА	НЗД-ын захирамжаар байгуулагдсан Төслийн урьдчилсан үнэлгээ болон бүрэн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсэгт журамд заасан холбогдох мэдээллүүдийг гаргаж өгч, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан. Улмаар Урьдчилсан үнэлгээний тайлан,	100%

						дүгнэлтийг 2025 оны 04-р сарын 17-ны өдөр НЗД баталсан. Мөн Бүрэн шинжилгээний дүгнэлтийг 2025 оны 05-р сарын 23-ны өдрийн НИТХ-аар хэлэлцүүлсэн ба төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн тухай НИТХ-ын 2025 оны 5-р сарын 26-ны өдрийн 25/84 дүгээр тогтоол гарсан болно.	
1.4	Төслийн үнэлгээ хийх эрсдэлийн	Журмын хэрэгжилтийг хангасан байх	Төслийн эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн байна.	I улирал	ТТА, ЗХНА, СЭЗА	Төслийн гадаад, дотоод хүчин зүйлсийг газрын бүх нэгжүүд тодорхойлж гарган эрсдэлийн иж бүрэн үнэлгээг мэргэжлийн судалгаа, шинжилгээний байгууллагатай хамтран гүйцэтгэсэн.	100%
1.5	Барилга угсралтын явцын хяналт, чанарын баталгаажуулалт хийх	Талбайн хяналтын дүгнэлт, бүртгэл	Барилгын ажил стандартын дагуу явагдаж буй	IV улирал	ТТА	“Дулааны тавдугаар цахилгаан станц (ДЦС-5)” төсөл нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд түншлэлийн төслийн үе шат бүрийг ханган хэрэгжиж байгаа бөгөөд төслийг хэрэгжүүлэх Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээг 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан. Гэвч энэхүү гэрээ нь батлагдсан уралдаант шалгаруулалтын баримт бичигт тусгагдсан хугацаанаас хойш байгуулагдсан тул төслийн хэрэгжилт анх товлогдсон хугацаанаас тодорхой хэмжээгээр хойшлоход хүрсэн.	100%

					<p>Төслийн зураг төслийг “Митайм Интернэйшнл” ХХК-ийн туслан гүйцэтгэгч “Повер Чайна Хэбэй Электрик Повер Инженер” компани боловсруулж байна. Төслийн талбайн бэлтгэл ажлын хүрээнд инженер геологийн ажил хийгдэж эхэлсэн.</p> <p>“ДЦС-2” ТӨХК-ийн эзэмшлийн үнсэн сангийн үлдсэн 5 га газрыг шилжүүлж төслийн талбай бэлдэхтэй холбоотой “ДЦС-2” ТӨХК-с “ДЦС-4” ТӨХК-ний багерь аж ахуй №2 руу үнсний шугамыг шилжүүлэх ажил, “ДЦС-4” ТӨХК-ийн багерын насосын хүчин чадлыг нэмэгдүүлэх, хуучин шугамыг өргөтгөх угсралтын ажил бүрэн дууссан.</p> <p>НИТХ-ын 2025 оны 12-р сарын 26-ны өдрийн 25/154 дүгээр тогтоолоор “ДЦС-5” ОНӨААТҮГ-ын дүрэмд өөрчлөлт оруулж, төслийн барилгын ажлын үе шатанд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийг олгосон.</p> <p>Улмаар Нийслэлийн Засаг даргын 2026 оны 01-р сарын 15-ны өдрийн “Түншлэлийн төсөлд захиалагчийн хяналт</p>	
--	--	--	--	--	---	--

						хэрэгжүүлэх тухай” А/40 дүгээр захирамж гарсан. Хувийн хэвшлийн түншлэгч “Митайм Интернэйшнл” ХХК-тай Захиалагчийн техник хяналтын гэрээ байгуулахаар ажиллаж байна.	
<b>Зорилт 2. Төсөлтэй холбоотой баримт бичгүүдийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргаар батлуулах</b>							
2.1	Сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулах	Боловсруулсан эх баримт бичиг	Нийслэлийн ЗДТГ-т хүргүүлж батлуулсан байна.	I улирал	ТТА, ЗХНА, СЭЗА	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/504, А/689 дүгээр захирамжаар байгуулагдсан Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг төслийн хувийн хэвшлийн түншлэгчийг сонгох сонгон шалгаруулалтын баримт бичгийг Засгийн газрын 2024 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу боловсруулж, Нийслэлийн Засаг даргаар батлуулсан.	100%
2.2	Баримт бичгийг холбогдох хууль, журамд нийцүүлэн сайжруулж НЗД-аар батлуулах	Баталсан тогтоол бүхий бичиг	Шалгаруулалтын процесс эхлэх нөхцөл бүрдсэн байна.	I улирал	ТТА, ЗХНА, СЭЗА	Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах баримт бичгийг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр НЗД-аар батлуулсан.	100%
<b>Зорилт 3. Урьдчилсан болон уралдаант шалгаруулалтыг амжилттай зохион байгуулахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллах</b>							
3.1	Урьдчилсан шалгаруулалтын зарлалыг олон нийтэд мэдээлэх	Зарлал нийтэд хүрсэн байх	Сонирхсон компаниуд оролцох нөхцөл бүрдсэн	I улирал	ЗХНА	Урьдчилсан шалгаруулалтын зарлалыг өдөр тутмын сонин хэвлэл, хэвлэлийн цахим хуудсуудад өгч байршуулав. Мөн НЗДТГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй хамтран	100%

						ажиллаж <a href="http://www.ulaanbaatar.mn">www.ulaanbaatar.mn</a> болон байгууллагын <a href="http://www.tpp5.mn">www.tpp5.mn</a> цахим хуудас дээр олон нийтэд нээлттэй байршуулсан.	
3.2	Санал хүлээн авч, шалгаруулалтын шалгуурт нийцүүлэн үнэлгээ хийх	Үнэлгээний хуудас, тэмдэглэлтэй	Шалгарсан оролцогчид тодорхой болсон	II улирал	ТТА, ЗХНА, СЭЗА	Урьдчилсан шалгаруулалтад оролцох саналыг 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 10.00 цаг хүртэл хүлээн авч, оролцох хүсэлт гаргасан 8 оролцогчоос 4 нь саналаа ирүүлсэн.  Ажлын хэсэг саналуудын иж бүрдэл, зааврын дагуу бэлтгэгдсэн байдал болон хуулийн шаардлагыг хянан, шаардлага хангасан саналуудыг оноогоор үнэлсний дүнд “Шунхлай Холдинг” ХХК, “Митайм Интернэйшнл” ХХК, “Чайна Уэстэрн Повер Индастриал” ХХК хураангуй жагсаалтад шалгарсан.	100%
3.3	Уралдаант шалгаруулалтын баримт бичиг боловсруулж, зарлах	Батлагдсан баримт бичгээр зарласан байх	Оролцогчдод тодорхой нөхцөл бүрдүүлсэн	III улирал	ТТА, ЗХНА, СЭЗА	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/504, А/689 дүгээр захирамжаар байгуулагдсан Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг уралдаант шалгаруулалтын баримт бичгийг түншлэлийн гэрээний төслийн хамт боловсруулж, Нийслэлийн Засаг даргаар 2025 оны 07-р сарын 07 -ны өдөр батлуулсан.	100%

					<p>Уралдаант шалгаруулалтыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Засгийн газрын 2024 оны 210 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Хувийн хэвшлийн түншлэгч болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/689 дүгээр захирамжаар баталсан Ажлын хэсгийн ажиллах удирдамж болон Нийслэлийн Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан “ДЦС5/202505” төслийн дугаартай “Дулааны тавдугаар цахилгаан станц (ДЦС-5) төслийн хувийн хэвшлийн түншлэгч сонгох уралдаант шалгаруулалтын баримт бичгийн хүрээнд зохион байгуулсан.</p> <p>Урьдчилсан шалгаруулалтаар богино жагсаалтад орсон оролцогчдод дараагийн шатны уралдаант шалгаруулалтын баримт бичгийг 2025 оны 07-р сарын 07-ны өдөр хүргүүлсэн. Уралдаант шалгаруулалтын төслийн саналыг 08 дугаар сарын 06-ны өдрийн 10 цаг хүртэл хүлээж авсан бөгөөд заасан хугацаанд багтаан “Митайм Интернэйшнл” ХХК,</p>	
--	--	--	--	--	---	--

						“Шунхлай Холдинг” ХХК гэсэн хоёр оролцогч төслийн саналаа ирүүлсэн.	
3.4	Саналыг хүлээн авч, үнэлж жагсаалт гаргах	Онооны дараалал бүхий жагсаалт	Шилдэг оролцогч тодорсон	III улирал	ТТА, ЗХНА, СЭЗА	Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдөр оролцогчдын төслийн саналыг үнэлж дууссан бөгөөд үнэлгээг холбогдох баримт бичгийн хамт Нийслэлийн Засаг даргад танилцуулсан. Үнэлгээний дүнгийн тухай албан мэдэгдлийг 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдөр оролцогчдод хүргүүлсэн.	100%
<b>Зорилт 4. Хувийн хэвшлийн түншлэгчтэй гэрээ байгуулах</b>							
4.1	Шалгарсан оролцогчтой гэрээний нөхцөлийн хэлэлцээр хийх	Хэлэлцээрийн протокол	Эвлэрсэн гэрээний төсөл бэлэн болсон байна	IV улирал	ТТА, ЗХНА, СЭЗА	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/1223 дугаар захирамжаар сонгон шалгаруулалтын үнэлгээгээр эрэмбэлэгдсэн оролцогчтой гэрээний хэлэлцээр хийх, гол нөхцөл тохирох чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.  Ажлын хэсэг нэгдүгээрт эрэмбэлэгдсэн оролцогчтой 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр гэрээний хэлэлцээг эхлүүлсэн бөгөөд 6 удаагийн хэлэлцээрийн үр дүнд 09 дүгээр сарын 25-ны өдөр гэрээний	100%

						төслийг харилцан тохиролцож, эцэслэсэн.	
4.2	НИТХ-д гэрээг танилцуулж батлуулах	НИТХ-ын тогтоол	Гэрээ хүчин төгөлдөр болсон байна	IV улирал	ТТА, ЗХНА, СЭЗА	Талуудын харилцан тохиролцсон гэрээний төслийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулсан ба улмаар 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 25/125 дугаар тогтоолоор Дулааны тавдугаар цахилгаан станц төслийн хувийн хэвшлийн түншлэгчтэй түншлэлийн гэрээ байгуулах эрхийг Нийслэлийн Засаг даргад олгосон.  “Дулааны тавдугаар цахилгаан станц (ДЦС-5)” төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх түншлэлийн гэрээнд 2025 оны 11 дугаар сарын 13-ны өдөр төрийн түншлэгчийг төлөөлж Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, хувийн хэвшлийн түншлэгчийг төлөөлж “Митайм Интернэйшнл” ХХК-ийн Ерөнхий захирал Тиан Хаомин нар гарын үсэг зурж, баталгаажуулсан.	100%
Зорилт 5. Барилга угсралтын бэлтгэл ажлыг дүрэмд заасан ажлын уялдаа холбоонд нийцүүлэн зохион байгуулах							
5.1	Барилга угсралтын төлөвлөгөө гаргах	Гэрээний барилга, угсралтын	Талууд хамтран баталгаажуулсан байна.	IV улирал	ТТА	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу барилга угсралтын төлөвлөгөөг	100%

		ажлын календарчилсан төлөвлөгөө				боловсруулан батлуулахаар Митайм Интернэйшнл ХХК-руу хүргүүлсэн.	
5.2	Барилга угсралтын ажлыг эхлүүлэх холбогдох зөвшөөрлүүдийг авах	Холбогдох хууль, дүрэм, журамууд	Ажил эхлэх зөвшөөрөл баталгаажсан байна.	IV улирал	ТТА, ЗХНА, СЭЗА	Төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх түншлэлийн гэрээ 2025 оны 11 дугаар сарын 13-ны өдөр байгуулагдсан. Барилга угсралтын төлөвлөгөөгөөр үндсэн ажлууд 2025 оны 11 дүгээр сараас эхэлсэн.  Түншлэлийн гэрээний 27 дугаар зүйлд төслийг хэрэгжүүлэх зорилгоор тусгай зориулалтын компани /ТЗК/-ийг хувийн хэвшлийн түншлэгч "Митайм Интернэйшнл" ХХК байгуулахаар тусгагдсан. ТЗК нь холбогдох тусгай зөвшөөрлүүдийг авна.  Манай газраас хамаарахгүй ажил тул үнэлэх боломжгүй.	-
5.3	Барилгын талбайн бэлтгэл, зураг төсөл боловсруулах	Газрын нөхцөл, зураг төслийн эх бэлэн	Барилгын эхлэлд бэлтгэл хангагдсан байна	IV улирал	ТТА	Төслийн зураг төслийг "Митайм Интернэйшнл" ХХК-ийн туслан гүйцэтгэгч Повер Чайна Хэбэй Электрик Повер Инженер компани боловсруулж байна.  Төслийн талбайн бэлтгэл ажлын хүрээнд Дулааны хоёрдугаар цахилгаан станцын дэд бүтцийг ашиглан шинээр Дулааны тавдугаар цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэхэд	60%

						<p>шаардлагатай дэд бүтцийн трассын дагуух газар чөлөөлөлтийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/107 дугаар тогтоолд тусгасны дагуу газар чөлөөлөлтийн нөлөөлөлд нийт 26 нэгж талбар өртсөнөөс 20 нэгж талбарыг бүрэн чөлөөлөн үлдсэн 6 нэгж талбартай зөвшилцөх ажил хийгдэж байна.</p> <p>“ДЦС-2” ТӨХК-ийн эзэмшлийн үнсэн сангийн үлдсэн 5 га газрыг шилжүүлэхтэй холбоотой “ДЦС-2” ТӨХК-с “ДЦС-4” ТӨХК-ний багерь аж ахуй №2 руу үнсний шугамыг шилжүүлэх ажил, “ДЦС-4” ТӨХК-ийн багерын насосын хүчин чадлыг нэмэгдүүлэх, хуучин шугамыг өргөтгөх угсралтын ажил бүрэн дууссан.</p> <p>Хувийн хэвшлийн түншлэгч “Митайм Интернэйшнл” ХХК нь төслийн талбайд геологийн судалгааны ажлын хүрээнд 20-25 м-ийн гүнтэй нийт 142 цооног өрөмдөх өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэж байна.</p>	
5.4	Импортын материалын жагсаалт, техникийн баримт бичгийг боловсруулж батлуулах	Мастер жагсаалт, тодорхойлолт	2026 оны угсралтын ажилд шууд хэрэгжих баримт бичиг бүрдсэн байна.	IV улирал	ТТА	<p>“Дулааны тавдугаар цахилгаан станц (ДЦС-5)” төсөл нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд түншлэлийн төслийн үе шат</p> <p>-</p>	

						<p>бүрийг ханган хэрэгжиж байгаа бөгөөд төслийг хэрэгжүүлэх Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээг 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан. Төслийн гэрээ нь батлагдсан уралдаант шалгаруулалтын баримт бичигт тусгагдсан хугацаанаас хойш байгуулагдсан тул зарим ажлууд хойшлоход хүрсэн.</p> <p>Тоног төхөөрөмжийн захиалга бүрэн хийгдсэнээр материалын жагсаалт бэлэн болно.</p> <p>Уг ажил төлөвлөсөн хугацаа хойшилж 2026 он руу шилжсэн.</p>	
5.5	Барилгын суурийн ажлын зургийг баталж, газар шорооны ажил эхлүүлэх	Барилгын талбайн зураг батлагдсан байх	Суурийн ажил эхэлсэн байна.	IV улирал	ТТА	<p>Төслийн зураг төслийг “Митайм Интернэйшнл” ХХК-ийн туслан гүйцэтгэгч Повер Чайна Хэбэй Электрик Повер Инженер компани боловсруулж байна. Төслийн талбайн бэлтгэл ажлын хүрээнд инженер геологийн ажил хийгдэж эхэлсэн.</p>	10%
5.6	Үндсэн бүтээц барих ажлын төлөвлөгөө гаргах, материалын захиалга хийх	Материал захиалсан баримт, хуваарьтай байх	Үндсэн бүтээц барих бүрдсэн нөхцөл	IV улирал	ТТА	<p>Төслийн батлагдсан уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасан хугацаанаас гэрээ байгуулах хугацаа хойшилсон тул захилгын ажил хойшилсон. Төслийн зураг төслийн ажил хийгдэж эхэлсэн. Тоног төхөөрөмж, бараа материал захиалах ажил эхэлсэн.</p>	10%

5.7	Импортын тоног төхөөрөмжийн худалдан авалтын гэрээ байгуулах	Гэрээ, үнийн санал, төлбөрийн нөхцөл баталгаажсан байх	Тоног төхөөрөмж худалдан авах эхлэл тавигдсан	IV улирал	ТТА	Төслийн батлагдсан уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасан хугацаанаас гэрээ байгуулах хугацаа хойшилсон тул тоног төхөөрөмж захилгын ажил хойшилж 2026 он руу шилжсэн.	10%
5.8	Худалдан авсан тоног төхөөрөмжийг тээвэрлэх, гаалийн бүрдүүлэлт хийх	Тээвэр, гаалийн баримт бүрдсэн байх	Тоног төхөөрөмж талбайд буусан	IV улирал	ТТА	Тоног төхөөрөмж, бараа материал худалдан авалтын үйл ажиллагаа хойшилж 2026 он руу шилжсэн.	-
5.9	Тоног төхөөрөмжийг суурилуулах зураг төсөл, ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах	Ажлын зураг, төлөвлөгөө батлагдсан байх	2026 онд шууд хэрэгжих боломж бүрдсэн	IV улирал	ТТА	Төслийн зураг төслийг "Митайм Интернэйшнл" ХХК-ийн туслан гүйцэтгэгч Повер Чайна Хэбэй Электрик Повер Инженер компани боловсруулж байна.  Төслийн батлагдсан уралдаант шалгаруулалтын баримт бичигт заасан хугацаанаас гэрээ байгуулах хугацаа хойшилсон тул зураг төсөл баталгаажуулах ажил хойшилж 2026 он руу шилжсэн.	-

Зорилт 6. Тайлагнал, хяналт-шинжилгээний тогтолцоог хэрэгжүүлэх

6.1	Төслийн гүйцэтгэлийн хяналт-шинжилгээний бүтэц, баг томилох	Хариуцсан гишүүд, тайлагнах үүрэгтэй байх	Хяналт-шинжилгээний систем бүрдсэн	II улирал	ТТА, ЗХНА, СЭЗА	Төслийг боловсруулсан.	10%
6.2	Үйл ажиллагааны гүйцэтгэлийн үзүүлэлт (KPI) тогтоох, тайлагнах, хуваарь батлах	KPI жагсаалт, тайлангийн хуваарь батлагдсан байх	Улирлын тайлан тогтмолжсон	II улирал	ЗХНА	Ажилтны гүйцэтгэлийг үнэлэх журмын төслийг боловсруулсан. Тус журам дээр гүйцэтгэлийн төлөвлөө болон бусад	80%

						хэмжүүрүүдийг хэрхэн үнэлэхийг тусгасан болно.	
6.3	Төслийн явцын тайлан боловсруулж, тайлагнана	Улирал тутмын тайлан боловсруулсан байх	Төслийн ил тод байдал хангагдсан	III-IV улирал	ТТА, ЗХНА, СЭЗА	Төслийн явцын тайланг улирал тутам болон шаардлагатай тохиолдолд боловсруулж, төслийн ил тод байдлыг ханган ажилласан. Төслийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг нэгтгэн Нийслэлийн Засаг даргад болон холбогдох байгууллагуудад тогтмол тайлагнан ажиллаж байна.	100%

### ХОЁР.ХУУЛИАР ОЛГОГДСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

#### Зорилт 7. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах

7.1	Нэгж, албан хаагчдын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлгээ өгч ажиллах	Улирал тутмын тайлан боловсруулсан байх	Төлөвлөгөөг гаргаж үнэлгээг улирал бүр өгсөн байна	I-IV улирал	ЗХНА	“ДЦС-5” ОНӨААТҮГ нь 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр УБЕГ-т бүртгүүлэн гэрчилгээ болон тамга тэмдгээ авсан. Тус өдрөөс эхлэн байгууллагын үйл ажиллагаа эхэлсэн бөгөөд хагас жилийн 2-р улирлын буюу хагас жилийн тайланг хийж дуусгасан.	100%
7.2	Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах	Хөтөлбөр батлагдсан байх	Хүний нөөцийн чадавх, ажиллах нөхцөл сайжирсан байна	I-IV улирал	ЗХНА	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмын төслийг боловсруулж, ажилтнуудын саналыг авч, газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/53 дугаар тушаалаар батлав.	100%
7.3	Байгууллагын 2025 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр өгөөжтэй, хэмнэлтэй зарцуулж, өр авлага	Сар бүрийн тайлан боловсруулсан байх	Жилийн эцсийн тайлан хянагдсан байна	I-IV улирал	СЭЗА	2025 оны батлагдсан төсвийн хүрээнд сар бүр төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээ гаргаж Нийслэлийн Өмчийн харилцааны газар хүргүүлэн	100%

	үүсгэхгүй байх, төсвийн тайлан мэдээг хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллах					ерөнхий нягтлан бодогчоор хянуулж батлуулсан.	
7.4	Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай, хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллах	Улирал бүрийн тайлан боловсруулсан байх	Шилэн дансанд мэдээлэл бүрэн байршуулсан байна	I-IV улирал	СЭЗА	Шилэн дансны тухай хууль болон "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу цаг тухай бүр холбогдох мэдээ тайланг шилэн дансны цахим системд нийтлэн ажиллаж байна.	100%
7.5	"Авлигатай тэмцэх 5Ш ажиллагаа"-ны хүрээнд хэрэгжүүлж буй "Шил ажиллагаа"-ны shilen.gov.mn цахим хуудсанд мэдээлэл оруулж ажиллах	Холбогдох мэдээллүүдийг боловсруулсан байх	Shilen.gov.mn цахим хуудсанд мэдээлэл бүрэн байршуулсан байна	I-IV улирал	ЗХНА	"Шил ажиллагаа"-ны shilen.gov.mn цахим хуудсанд мэдээлэл оруулж 2-р улирлын тайланг хуулийн хугацаанд илгээсэн.	100%
7.6	Бодлогын болон захирамжлалын баримт бичиг, дээд газраас ирсэн тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг нэгтгэх, холбогдох дээд шатны байгууллагад хугацаанд нь тайлагнах, тэдгээрийн биелэлтэд болон байгууллагын үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргаж,	Биелэлтийг цаг тухай бүр цаг хугацаанд нь гүйцэтгэсэн байх	Жилийн эцсийн тайланд мэдээлэл тусгасан байна	I-IV улирал	ЗХНА	НИТХ-ын 2025 оны 25/50 тоот тогтоолоор "ДЦС-5" ОНӨААТҮГ-ын бүтэц, орон тоо, үйл ажиллагааны зардлыг батлуулсан. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/458 дугаар захирамжаар 2025 оны санхүүжилтийн хуваарийг батлуулсан. БГД-ийн 20 дугаар хороонд "ДЦС-5" ОНӨААТҮГ-т Цахилгаан, эрчим хүчний барилга байгууламж зориулалтаар 101999 м.кв	100%

	удирдлагыг мэдээллээр хангаж ажиллах					<p>газрыг 40 жилийн хугацаатай эзэмших гэрчилгээг авсан.</p> <p>"ДЦС-5" ОНӨААТҮГ-ын Удирдах зөвлөлийн 03 тоот тогтоолоор 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг, 07 тоот тогтоолоор хөдөлмөрийн дотоод журам, цалин хөлсний журам болон албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэх журмуудыг тус тус батлуулсан.</p> <p>Мөн дээд газраас ирсэн тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг нэгтгэх, холбогдох дээд шатны байгууллагад хугацаанд нь тайлагнах, тэдгээрийн биелэлтэд дүгнэлт, зөвлөмж гаргаж, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллаж байна.</p>	
7.7	<p>Албан хэрэг хөтлөлт, <a href="https://edoc.ulaanbaatar.mn">https://edoc.ulaanbaatar.mn</a> цахим системээр болон цаасаар ирсэн албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэх, баримт бичгийг стандартын дагуу боловсруулах, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж үүсгэх</p>	Албан бичиг шийдвэрлэлт зөрчилгүй байх	Архивын бүрдэл материал үүсгэсэн байна	I-IV улирал	ЗХНА	<p>Нийслэлийн архивын газраас Албан хэрэг хөтлөлтийн "eDoc" системийн эрх нээлгүүлж, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг эхлүүлсэн.</p> <p>2025 онд edoc систем болон цаасаар нийт 124 албан бичиг хүлээн авч, танилцаж, хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажиллалаа. Мөн нийт 184 албан бичгийг бусад байгууллага руу явуулсан байна. Байгууллагын архивын нийтлэг журмын дагуу жишиг Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг албадаас санал авч</p>	100%

						боловсруулсан. Баримт бичгийн эмх цэгцтэй байдалд анхаарч, холбогдох дүрэм журмыг мөрдөж, хэрэгжилтийг тогтмол хангаж ажиллалаа. 2025 оны онд хөтлөгдсөн баримт бичгийг 2026 оны 01 дүгээр улиралд архивт хүлээлгэн өгөх чиглэлээр хадгаламжийн нэгжийг холбогдох стандартын дагуу бүрдүүлэн ажиллаж байна.	
7.8	Газрын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журмыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах	Холбогдох журмуудыг боловсруулсан байх	Журмыг хэрэгжилтийг ханган ажиллана	I-IV улирал	ЗХНА	Газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/12 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг, 2 дугаар хавсралтаар Цалин хөлсний журмыг, мөн өдрийн А/13 дугаар тушаалаар байгууллагын Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг, 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/53 дугаар тушаалаар байгууллагын Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг, мөн өдрийн А/54 дүгээр тушаалаар байгууллагын ажилтны Ёс зүйн дүрмийг тус тус баталж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.	100%
7.9	Байгууллагын үйл ажиллагаанд жендерийн тэгш байдлыг хангах,	Хүйсийн харьцаа алдагдалгүй байх, ХАБЭА-н	Жилийн эцсийн тайланд	I-IV улирал	ЗХНА, ХАБЭА	Байгууллагын бүтцэд хүйсийн тэгш харьцааг алдуулахгүй байж, ажлын байрны аюулгүй	100%

	хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангасан нөхцөлийг бүрдүүлэх	журам батлагдсан байх	мэдээлэл тусгасан байна		хяналтын инженер	байдал, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллаж байна.	
7.10	Хөдөлмөрийн тухай хуулийг байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлж, мөрдөж ажиллах	Хөдөлмөрийн хуулийг зөрчихгүй байх	Жилийн эцсийн тайланд мэдээлэл тусгасан байна	I-IV улирал	ЗХНА	Байгууллагын хүний нөөцийн буюу Б тушаалуудыг хөдөлмөрийн тухай хуулийн дагуу боловсруулан батлуулж, мөрдөн ажиллаж байна.	100%
7.11	Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах	Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулсан байх	2025 оны төлөвлөгөө биелсэн байна	I-IV улирал	ЗХНА	Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төслийг эхний байдлаар боловсруулж танилцуулсан.	80%
<b>Зорилт 8. Санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хэвийн явуулах</b>							
8.1	Бизнес болон хэтийн төлөвлөгөө, сар улирлын зардлын төлөвлөгөө худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, батлуулах	Холбогдох хууль журмыг баримтлан төлөвлөгөө боловсруулах	Хуулийн хугацаанд багтаан батлуулсан байна	II-IV улирал	СЭЗА	2025 онд Нийслэлийн засаг даргын захирамжаар батлагдсан төсвийн хүрээнд ХАА-ны төлөвлөгөө болон зардлын ангилал тус бүрээр төсөв боловсруулан батлуулан ажилласан.	100%
8.2	Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг сар, улирлаар хангуулах, биелэлтийг удирдлагад танилцуулах.	Тухай бүр хэрэгжилтийг хангаж ажиллах	Сар улирлын батлагдсан төлөвлөгөө хэрэгжсэн байна	II-IV улирал	СЭЗА	2025 оны батлагдсан төсвийн биелэлтийг сар бүр гаргаж СЭЗА-ны дарга болон байгууллагын удирдлагаар хянуулан, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын ерөнхий нягтлангаар хянуулан ажилласан..	100%
8.3	Удирдлагыг санхүү, эдийн засгийн мэдээллээр шуурхай мэдээллээр хангаж,	Холбогдох мэдээллийг тогтмол,	Удирдлагыг өдөр тутмын үйл ажиллагаатай	II-IV улирал	СЭЗА	Байгууллагын удирдлагыг санхүү, эдийн засгийн	100%



	санхүүгийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулахад анхаарч ажиллах	шуурхай өгч ажиллах	холбоотой санхүү бүртгэлийн мэдээллээр бүрэн хангасан байна			мэдээллээр цаг тухай бүр шуурхай ханган ажилласан.	
8.4	Байгууллагын худалдан авах төлөвлөгөөг хянах, шилэн дансны цахим хуудсанд байршуулах	Цахим системд хуулийн дагуу мэдээллийг тухай бүр оруулах	Хуулийн заалтын дагуу орлого зарлагын мэдээг хугацаанд нь бүрэн толилуулсан байна	II-IV улирал	СЭЗА	Байгууллагын батлагдсан ХАА-ны төлөвлөгөөний дагуу шууд худалдан авалтыг төлөвлөсөн цаг хугацаанд нь тухай бүр худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгцээ шаардлагатай тавилга эд хогшил, компьютер техник хэрэгслийг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу харьцуулалтын аргаар худалдан авсан.	100%
8.5	Сар, улирал, жилийн санхүүгийн болон НД-ын тайлан, татварын тайлан мэдээг гаргаж холбогдох байгууллагуудад цахим хэлбэрээр хүргүүлэх	Харъяа дүүргийн НДГазар, татварын хэлтэс болон бусад байгууллагад холбогдох тайлан мэдээллийг илгээх	Сар. Улирлын тайлан мэдээг тухайн тайлант хугацаанд хоцроохгүй толилуулсан байна	II-IV улирал	СЭЗА	Нийгмийн даатгалын тайлан болон ХХОАТ-ын тайлан мэдээг сар бүр гаргаж, холбогдох байгууллагын цахим системээр тухай бүр илгээж ажилласан.	100%
8.6	Сар бүрийн үйл ажиллагааны зардлын төсвийг батлагдсан хуваарийн дагуу Нийслэлийн өмчийн харилцааны газарт нэхэмжлэх илгээх байгууллагын дансанд татан шилжүүлэх	НЗД-ын захирамжийг үндэслэн батлагдсан хуваарийн дагуу олгогдох	Сар бүрийн эхэнд байгууллагын дансанд төвлөрсөн байна	II-IV улирал	СЭЗА	2025 онд батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу тухай бүр Нийслэлийн Өмчийн харилцааны газарт нэхэмжлэл илгээн байгууллагын харилцах дансанд татан байршуулсан.	100%

8.7	Улирлын санхүүгийн тайланд тодруулга хийж холбогдох ЭХЯ, ЭХЗХ, НЗДТГ-н Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлэх	Холбогдох дээд шатны байгууллагуудад сар, улирлын тайлан мэдээ хүргүүлж, гүйцэтгэл хянуулах	Гүйцэтгэлийг холбогдох байгууллагаар тухай бүр хянуулан, сар улирлын тайлан мэдээнд тусгасан байна	II-IV улирал	СЭЗА	2025 оны үйл ажиллагаатай холбоотой сар, улирал бүрийн тайлан мэдээ гаргаж Нийслэлийн Өмчийн харилцааны газар болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хөрөнгө оруулалтын газар, Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн ажилласан.	100%
8.8	Байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагаанд оролцох, удирдлагаас өгсөн бусад үүрэг даалгаврыг биелүүлэх, тайлагнах	Биелэлтийг цаг тухай бүр хугацаанд нь гүйцэтгэсэн байх	Жилийн эцсийн тайланд мэдээлэл тусгасан байна	II-IV улирал	СЭЗА	Байгууллагын удирдлагаас өгсөн бусад үүрэг даалгаврыг цаг тухай бүр биелүүлж ажилласан.	100%
Зорилт 9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, стандарт, дүрэм журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд							
9.1	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг байгуулах	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг томилсон газрын даргын А тушаал төслийг бэлдсэн байна	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын газрын даргын А тушаал гарсан байна	II улирал	ХАБЭА хяналтын инженер	 <p>Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын газрын даргын А тушаалаар батлуулах төсөл бэлэн болсон.</p>	100%

						Хувийн хэвшлийн түншлэгчтэй дахин зөвшилцөн батална	
9.2	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх (цаашид аюултай тохиолдол гэх) журам боловсруулан, батлуулах	Аюултай тохиолдлыг судлан бүртгэх журмын төсөл боловсруулсан байна	Аюултай тохиолдлыг судлан бүртгэх журмыг, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын тушаалын хавсралтаар батлуулсан байна	II улирал	ХАБЭА хяналтын инженер	 <p>Аюултай тохиолдлыг судлан бүртгэх журмын төсөл бэлэн болсон. Хувийн хэвшлийн түншлэгчтэй дахин зөвшилцөн батална.</p>	100%
9.3	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл байгуулах	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл байгуулж, газрын даргын А тушаалын төсөл боловсруулсан байна	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл байгуулж, газрын даргын А тушаал гарсан байна	II улирал	ХАБЭА хяналтын инженер	 <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн журмын төсөл бэлэн болсон. Хувийн хэвшлийн түншлэгчтэй дахин зөвшилцөн батална.</p>	100%

9.4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн ажиллах журмыг боловсруулан, батлуулах	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн журмын төслийг боловсруулсан байна	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн А тушаалын хавсралтаар батлуулсан байна	II улирал	ХАБЭА хяналтын инженер	 <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн ажиллах журмын төсөл бэлэн болсон. Хувийн хэвшлийн түншлэгчтэй дахин зөвшилцөн батална</p>	100%
9.5	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын хяналтын журам	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын хяналтын журмын төсөл боловсруулсан байна	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын хяналтын журам газрын даргаар батлуулсан байна	II улирал	ХАБЭА хяналтын инженер	 <p>Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын хяналтын журмын төсөл бэлэн болсон.</p>	100%

9.6	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн хяналтын журам	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн хяналтын журмын төсөл боловсруулсан байна	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн хяналтын журам газрын даргаар батлуулсан байна	II улирал	ХАБЭА хяналтын инженер	 <p>ХЭМАС-ЫН ЭРСДЭЛИЙН ХЯНАЛТЫН ЖУРАМ</p>  <p>Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн хяналтын журмын төсөл бэлэн болсон. Хувийн хэвшлийн түншлэгчтэй дахин зөвшилцөн батална</p>	100%
9.7	Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын сургалт, зааварчилгааны журам	Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын сургалт, зааварчилгааны журмын төсөл боловсруулсан байна	Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын сургалт, зааварчилгааны журам газрын даргаар батлуулсан байна	II улирал	ХАБЭА хяналтын инженер	 <p>ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТ, ЗААВАРЧИЛГААНЫ ЖУРАМ</p>  <p>Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын сургалт, зааварчилгааны журмын төсөл бэлэн болсон. Хувийн хэвшлийн түншлэгчтэй дахин зөвшилцөн батална.</p>	100%

9.8	Ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл олгох норм	Ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл олгох норм, нормативын төсөл боловсруулсан байна	Ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл олгох норм, норматив газрын даргын А тушаал гарсан байна	II улирал	ХАБЭА хяналтын инженер	 <p>Ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг олгох, хэрэглэх, хяналт тавих журмын төсөл бэлэн болсон. Хувийн хэвшлийн түншлэгчтэй дахин зөвшилцөн батална</p>	100%
9.9	9.9 Ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг олгох, хэрэглэх, хяналт тавих журам	Ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг олгох, хэрэглэх, хяналт тавих журмын төсөл боловсруулсан байна	Ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл олгох норм, норматив газрын даргын А тушаалын хавсралтаар батлуулсан байна	II улирал	ХАБЭА хяналтын инженер		100%

						 <p>Ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг олгох, хэрэглэх, хяналт тавих журмын төсөл бэлэн болсон. Хувийн хэвшлийн түншлэгчтэй дахин зөвшилцөн батална.</p>	
9.10	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл хуралдуулах	ХЭМАБ-ын зөвлөлийн хурлыг зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэрийг үндэслэн төлөвлөгөө гаргасан байна	ХЭМАБ-ын зөвлөлийн хурлыг зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлсэн байна	IV улирал	ХАБЭА хяналтын инженер	НИТХ-ын 2025 оны 12-р сарын 26-ны өдрийн 25/154 дүгээр тогтоолын дагуу "ДЦС-5" ОНӨААТҮГ-ын дүрэм, бүтцэд өөрчлөлт оруулсны дараа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийг байгуулж, зөвлөлийг хуралдуулна.	100%
9.11	Ажил олгогчийн сургалтад хамруулах	Төрийн захиргааны дээд байгууллага баталсан дүрэм, журмын дагуу зохион байгуулна	Ажил олгогчийн сургалтад удирдлага, ИТА нарыг хамруулсан байна	IV улирал	ХАБЭА хяналтын инженер	2025 оны 8 сард ажил олгогч эздийн сургалтад нийт 7 удирдах ажилтан болон ИТА нарыг сертификаттай сургалтад хамруулсан.	100%
9.12	Эрсдэлтэй ажлын байрны сургалт зохион байгуулах	Төрийн захиргааны дээд байгууллага баталсан дүрэм, журмын дагуу	Эрсдэлтэй ажлын байрны сургалт зохион байгуулсан байна	IV улирал	ХАБЭА хяналтын инженер	Эрсдэлтэй ажлын байрны сургалтыг 2026 оны төсөвт суулгасан.	100%

		зохион байгуулах					
9.13	Тусгай эрхийн сургалтад ажилтнуудыг хамруулах	Төрийн захиргааны дээд байгууллага баталсан дүрэм, журмын дагуу зохион байгуулах	Тусгай эрхийн сургалт зохион байгуулсан байна	IV улирал	ХАБЭА хяналтын инженер	Тусгай эрхийн сургалтыг 2026 оны төсөвт суулгасан.	100%
9.14	Нийт ажилтны сургалт зохион байгуулах	Төрийн захиргааны дээд байгууллага баталсан дүрэм, журмын дагуу зохион байгуулах	Нийт ажилтны сургалт зохион байгуулсан байна	IV улирал	ХАБЭА хяналтын инженер	Нийт ажилтны сургалтыг 2026 оны төсөвт суулгасан.	100%
9.15	ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалт зохион байгуулах	Төрийн захиргааны дээд байгууллага баталсан дүрэм, журмын дагуу зохион байгуулах	ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалтад ИТА нарыг хамруулсан байна	IV улирал	ХАБЭА хяналтын инженер	ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалтыг 2026 оны төсөвт суулгасан.	100%
9.16	Гаднын сайн туршлага судлах	Гаднын сайн туршлага судалж туршлага нэмэгдүүлэх	Гаднын сайн туршлага судалж туршлага нэмэгдсэн байна	IV улирал	ХАБЭА хяналтын инженер	ТЭЗҮ болон үйл ажиллагааны хүрээнд тодорхой улсуудын туршлага судалсан Гаднын сайн туршлага судлах ажлыг 2026 оны төсөвт суулгасан.	100%
9.17	Эрсдэл бууруулах төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтэд хяналт тавих	Эрсдэл бууруулах төлөвлөгөө батлуулсан байна	Эрсдэл бууруулах төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьсан байна	III-IV улирал	ХАБЭА хяналтын инженер	Эрсдэл бууруулах нарийвчилсан төлөвлөгөөг "Митайм Интернэйшнл" ХХК-д санал авахаар хүргүүлсэн.	100%

9.18	Ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах, бүртгэх, хяналт тавих журмын хэрэгжилтэд хяналт тавих	Журмыг хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж сайжруулалтыг хүргүүлсэн байна	Бүх ажилтад ажлын хувцас олгоно	III улирал	ХАБЭА хяналтын инженер	2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Хөдөлмөр хамгааллын зардалд 4,135,000 төгрөг нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 4,305,920 төгрөг нийт <b>8,440,920</b> төгрөгийн төсөвт өртгөөр худалдан авалт хийхээр төлөвлөгөөнд тусгагдсан. Нийт төсөвлөгдсөнөөс 93 хувийн гүйцэтгэлтэй худалдан авалтыг 4 төрлөөр хийж гүйцэтгэсэн. Үүнд: Нийт 15 инженер техникийн ажилтанд 7,800,500 төгрөгөөр ажлын гутал 15, хамгаалалтын хантааз 15, хамгаалалтын нүдний шил 15, духны гэрэл 15 ширхгийг худалдан авсан	100%
9.19	Хүнсний нэмэлт бүтээгдэхүүний олголтод хяналт тавих	Хүнсний нэмэлт бүтээгдэхүүний жагсаалт гаргаж санал авсан байна	Хүнсний нэмэлт бүтээгдэхүүн олгосон байна	IV улирал	ХАБЭА хяналтын инженер	2026 онд хүнсний нэмэлт бүтээгдэхүүн олгохоор төсөвт суулгасан.	100%
9.20	Ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах	Нийт ажилтныг амь нас, эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд хамруулах ажлын даалгавар гаргасан байна	Нийт ажилтныг амь нас, эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд хамруулсан байна	II улирал	ХАБЭА хяналтын инженер	2026 оны төсөвт суулгасан. Ажлын даалгавар бэлэн болсон.	100%
9.21	Нийт ажилтны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хяналт тавих	Ажлын даалгавар гаргаж,	Үзлэг шинжилгээг журмын дагуу хийж буйд	IV улирал	ХАБЭА хяналтын инженер	2026 онд нийт ажилтны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар төсөвт суулгасан.	100%

		батлуулсан байна	хяналт тавьсан байна				
<b>Зорилт 10. Дотоод аудитыг хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулж хэрэгжилтийг хангах</b>							
10.1	Газрын даргаас өгсөн үүрэг даалгавар, гарсан тушаал шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, түүний хэрэгжилт, үр нөлөөтэй байдалд үнэлэлт дүгнэлт өгөх	Газрын даргын тушаал, шийдвэрийн хэрэгжилтийн хувь хэмжээг тодорхойлж, үүрэг даалгаврын биелэлтийн хугацаа, чанарт үнэлгээ өгөхөөс гадна дүрэм, журмын хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчлийн тоог тогтооно.	Тушаал, даалгаврын хэрэгжилт 90 хувиас дээш, дүрэм, журмын мөрдөлт 95 хувиас дээш байна.	II улирал	Дотоод аудитор	Дотоод аудитын төлөвлөгөөт ажлын хүрээнд хуваарийн дагуу ажил хийгдсэн.	100%
10.2	Санхүүгийн төсөв, төлөвлөгөө, бүртгэл, гүйцэтгэл, худалдан авалт зэрэг санхүү бүртгэлийн үндсэн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх /худалдан авах үйл ажиллагаа, санхүү бүртгэл, авлага, өр төлбөр, үндсэн хөрөнгө, сэлбэг, шатахуун, хангамжийн материал, цалин хөлс, татвар, нийгмийн даатгал, болон бусад/	Санхүүгийн бүртгэл хөтлөлтийн бүрдэл, үнэн зөв байдлыг үнэлж, санхүүгийн төсөв, төлөвлөгөөний биелэлтийн түвшинг үнэлнэ.	Санхүүгийн бүртгэл зөрчилгүй, бүрэн, үнэн зөв хөтлөгдөж, төсөв, төлөвлөгөөний гүйцэтгэл 90 хувиас дээш, худалдан авалт хууль, журмын дагуу хэрэгжсэн байна	II, IV улирал	Дотоод аудитор	Дотоод аудитын батлагдсан төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт аудит хийгдсэн.	100%

10.3	Албаны дүрэм, журам, стандарт, төлөвлөгөө, гүйцэтгэл, үр ашиг, ажлын байрны нөхцөл, шаардлага, зэрэг асуудлуудын нөхцөл байдал, хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх	Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, үүрэг хариуцлага хэрхэн хэрэгжиж байгааг үнэлж, албаны дүрэм, журмыг баталгаатай мөрдөж байгаа эсэхийг тодорхойлно.	Албаны дүрэм, журам, стандарт, төлөвөгөөний хэрэгжилт 95 хувиас дээш байна.	III улирал	Дотоод аудитор	Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, үүрэг хариуцлагын талаар төлөвлөгөөт бус хяналтыг хэрэгжүүлж тухай бүр зөвлөгөө өгч ажилласан.	60%
10.4	Захиргаа, хүний нөөцийн албаны үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлт, холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилт, хүний нөөц, зардал, үр ашигт байдал зэрэг үйл ажиллагаатай холбоотой асуудлуудад үнэлэлт, дүгнэлт өгөх	Захиргаа, хүний нөөцийн албаны төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлыг үнэлж, холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хянаж, мөрдөлтийн түвшинг тодорхойлно.	Албаны үйл ажиллагаа байгууллагын зорилт, бодлогод нийцэж, захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаа үр дүнтэй болно.	IV улирал	Дотоод аудитор	Захиргаа, хүний нөөцийн албаны үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналтыг оны эцсийн байдлаар хийсэн бөгөөд дөрөвдүгээр улиралд багтаан дүгнэлтийг гаргаагүй байна.	70%
10.5	Газрын даргаас өгсөн үүрэг, даалгаврын дагуу аудитын шалгалт хийх	Үүрэг, даалгаварт тулгуурласан шалгалтын гүйцэтгэл нь холбогдох хууль, журмын шаардлагад нийцсэн эсэхийг тодорхойлж, газрын даргын өгсөн үүрэг,	Үүрэг, даалгаварт тулгуурласан шалгалтын үр дүнд тухайн албаны үйл ажиллагаа холбогдох хууль, журмын шаардлагад нийцэж,	I-IV улирал	Дотоод аудитор	Төлөвлөгөөний дагуу тухай бүр газрын даргын үүрэг даалгаврын дагуу аудит хийгдсэн.	100%

		даалгаврын дагуу аудитын арга хэмжээ авагдсан эсэхийг шалгана.	гүйцэтгэл нэмэгдэнэ.				
10.6	Дотоод аудитын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, гүйцэтгэсэн аудитын тайлан, түүний мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн талаар Газрын даргад тухай бүр тайлагнан танилцуулах	Гүйцэтгэсэн аудитын тайлангуудыг Газрын даргад цаг хугацаанд нь танилцуулсан байх, аудитын тайлангийн мөрөөр авсан арга хэмжээ, биелэлтийн байдлыг бүртгэж, мэдээлж үнэлнэ.	Гүйцэтгэсэн бүх аудитын тайланг хугацаанд нь Газрын даргад танилцуулж, тайлагналын үр дүнд удирдлагын зүгээс шийдвэр гаргалт, хэрэгжилтэд ахиц гарахаас гадна аудитын дүгнэлтийн мөрөөр хэрэгжсэн арга хэмжээний биелэлт 90 хувиас дээш байна.	II-IV улирал	Дотоод аудитор	Дотоод аудитын жилийн төлөвлөгөөний дагуу тухайн нэгжид аудит хийгдсэний дараа зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан.	100%
<b>ДУНДАЖ ХУВЬ</b>							<b>92.3 %</b>

Төлөвлөгөөг хянасан:  
 “ДЦС-5” ОНӨААТҮГ-ЫН  
 УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

Л.ХОСБАЯР

2026.01.21  
 (огноо)

Төлөвлөгөөг тайлагнасан:  
 “ДЦС-5” ОНӨААТҮГ-ЫН ДАРГА:

А.БЯМБАДОРЖ

2026.01.21  
 (огноо)



7130697 УТА579 9025030502